

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**2011 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот**Хүний эрхийн талаар авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүний эрхийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/цагдаагийн байгууллагын өнөөгийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлын хүрээнд хэв журам хамгаалах болон эрүүгийн хэргийг мөрдөн шалгах гэсэн үндсэн чиг үүргүүдийг нь нарийвчлан тодорхой зааглах, цагдаагийн байгууллагын боловсон хүчин бэлтгэх тогтолцоог дээрх чиг үүргээр ялгамжтай зохион байгуулах, сургалтын хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, цагдаагийн хэв журам сахиулах чиг үүрэгт орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын оролцоог бүрэн хангах чиглэлд бодлого боловсруулах, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг мөрдөх алба болгон өөрчлөн зохион байгуулах, эрүүгийн хэргийн болон тагнуулын гүйцэтгэх ажлын чиг үүргийг нарийн зааглах, тагнуулын байгууллагад байгаа эрүүгийн хэрэг мөрдөх чиг үүргийг мөрдөх албанд шилжүүлэх, мөрдөх албаны чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, хяналт хариуцлагатай холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах, гэрч хохирогчийн хамгааллын эрх зүйн орчинг сайжруулах чиглэлд бодлого боловсруулж, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/цагдаагийн байгууллагыг олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангах, галт зэвсэг хэрэглэх болон хэрэгсэлтэй холбоотой тайлагнах үйл ажиллагааг нарийвчлан хуульчилах, хариуцлагыг тодорхой болгох чиглэлд бодлого боловсруулах;

4/цагдаагийн байгууллагын дотоод хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулж, түр саатуулах болон мөрдөн байцаах өрөө зэрэг хүний эрхийн зөрчил ихээр гарч буй хэсгүүдийг камержуулах, цагдаагийн камерын болон холбооны хэрэгслийн бичлэгийг хадгалах, хянах үйл ажиллагааг хуульчилах, хөндлөнгийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, энэ чиглэлд Хүний эрхийн Үндэсний Комиссын хяналтын эрх хэмжээг нэмэгдүүлэх, хүний эрхийн зөрчсөн болон зөрчлийн талаар арга хэмжээ аваагүй албан тушаалтанд тооцох хариуцлагыг чангатгах, нөлөөллийг сайжруулах бодлого боловсруулж, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/ прокурорын байгууллагын хэрэгжүүлж буй хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын зарим тодорхой чиг үүргийг шүүхэд шилжүүлэх, прокурорыг зөвхөн яллагчийн байр суурь, мөрдөх ажиллагааг удирдах эрх хэмжээтэй байхаар бодлого боловсруулж, шаардлагатай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

6/ шүүхэд мөрдөн байцаалтын шатны хяналтын шүүгчийн бүтэц, түүний үйл ажиллагааны журмыг бий болгох, шүүхийг тойргийн тогтолцоонд оруулах, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд халдаж буй дээд шатны шүүхийн захиргааны оролцоог шүүхийн бүх шатанд халах, шүүх болон захиргааны үйл ажиллагааг салгах чиглэлд бодлого боловсруулж, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7/бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч захиргааны эрх мэдэл хэрэгжүүлдэг байдлыг халах, Шүүхийн ерөнхий зөвлөлийг байнгын ажиллагаатай болгон зохион байгуулах, шүүхийн захиргааг мэргэшүүлэх чиглэлд бодлого боловсруулж, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

8/ Монголын өмгөөлөгчдийн холбоог Хуульчдын танхим /холбоо/ болгон өргөжүүлэн зохион байгуулах, хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх, хууль зүйн туслалцаа, өмгөөллийн зохион байгуулалт, тэр дундаа стратегийн өмгөөллийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, өмгөөлөгчдийн шүүн таслах үйл ажиллагаан дахь оролцоог нэмэгдүүлэх, харилцагчийнхаа эрх ашгийг хамгаалах хууль зүйн баталгааг сайжруулах, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх, хуульчдын үргэлжилсэн сургалтын агуулга, арга зүйд хуульчдад хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах ур чадварыг бий болгох чиглэлийг нэмэгдүүлэх, хүний эрхийн асуудлыг хуульчдын ажил, мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгуурын гол үзүүлэлт болгох, хуульчдыг лицензийн тогтолцоонд оруулах талаар бодлого боловсруулж, шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

9/цагдаагийн бие бүрэлдэхүүний чадавхийг тэр дундаа цагдаагийн алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэл болон ажлын ур чадварыг дээшлүүлэх, тэдэнд зориулсан сэтгэл зүйн заслын дэд бүтэц бий болгох, Цагдаагийн бие бүрэлдэхүүнд хүний эрхийн хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн давтан сургалтын арга, хэлбэрийг хөгжүүлэх, хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай энэ чиглэлээр хамтран ажиллах болон гадагш хандсан тайлагнах тогтолцоог сайжруулах, иргэд, олон нийтийн итгэл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэвшүүлэх арга хэмжээ авах, зардлыг төсөвт тусгайлан суулгах.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт дурдагдсан холбогдох бодлого төслүүдийг 2012 оны хаврын ээлжит чуулганд багтаан өргөн мэдүүлэхийг Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.